



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хот Дугаар 58 Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1. “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/ -т даалгасугай: 1/ “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсэд зориулан олгох газрын хэмжээ, бүсийн хилийн цэсийг нарийвчлан тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 2/ “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан эхний ээлжинд авах арга хэмжээний төлөвлөгөө гарган дэс дараатай хэрэгжүүлж ажиллах. 2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо / Т.Очирхүү/-нд даалгасугай. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ